



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/251/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261628 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Ж.Нямцэцэг
Утас: 261628 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: “Голден пэйж Аудит” ХХК
Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл
Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Зөвлөмж.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ДАРГА,
АХМАД Х.БАТБАЯР ТАНАА

2022.02.24 № 07/317
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,148,793.77	43,127,043.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,000.00	1,186,919.57
312	Банканд байгаа бэлэн мөнгө	20,000.00	1,186,919.57
3121	Төгрөг	20,000.00	1,186,919.57
31211	Төрийн сангийн харилцах	20,000.00	1,186,919.57
33	АВЛАГА	-	50,490.96
335	Бусад авлага	-	50,490.96
3351	Байгууллагаас авах авлага	-	50,490.96
35	БАРАА МАТЕРИАЛ	43,128,793.77	41,889,632.77
354	Хангамжийн материал	43,128,793.77	41,889,632.77
35410	Бичиг хэргийн материал	9,360,396.00	9,884,818.00
35420	Аж ахуйн материал	23,566,482.77	24,251,129.77
35440	Түлш, шатах тослох материал	712,700.00	614,600.00
35470	Бусад хангамжийн материал	9,489,215.00	7,139,085.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	34,754,870.38	26,981,120.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	34,754,870.38	26,981,120.64
392	Биет хөрөнгө	34,449,742.09	26,937,530.79
39203	Авто-тээврийн хэрэгсэл	43,000,000.00	43,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(43,000,000.00)	(43,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	70,015,667.60	60,574,667.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(48,021,876.02)	(42,931,054.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,403,936.00	31,559,049.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,947,985.49)	(22,265,131.42)
393	Биет бус хөрөнгө	305,128.29	43,589.85
39301	Программ хангамж	4,437,692.31	4,437,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,132,564.02)	(4,394,102.46)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	77,903,664.15	70,108,163.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,000.00	-
413	Өглөг	20,000.00	-
4136	Бусад өглөг	20,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	20,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	77,883,664.15	70,108,163.94
51	Засгийн газрын хувь оролцоо	77,883,664.15	70,108,163.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38,997,652.44	38,997,652.44
51101	Өмч: - төрийн	38,997,652.44	38,997,652.44
512	Хуримтлагдсан үр дүн	38,886,011.71	31,110,511.50
51210	Өмнөх үеийн үр дүн	38,886,011.71	38,886,011.71
51220	Тайлант үеийн үр дүн	-	(7,775,500.21)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	77,903,664.15	70,108,163.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	377,215,100.00	379,776,236.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	629,300.00	4,327,936.00
120	Нийтлэг татварын бус орлого	629,300.00	4,327,936.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	629,300.00	4,327,936.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	629,300.00	4,327,936.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	376,585,800.00	375,448,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	376,585,800.00	375,448,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	376,585,800.00	375,448,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	378,297,031.53	387,551,736.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,297,031.53	387,551,736.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	377,591,919.45	383,825,711.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,284,466.95	304,308,989.47
210101	Үндсэн цалин	211,178,066.95	192,947,300.00
210102	Нэмэгдэл	102,106,400.00	107,707,689.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,000,000.00	2,646,000.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,008,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,480,520.97	6,205,575.74
210201	Тэтгэврийн даатгал	-	90,611.80
210202	Тэтгэмжийн даатгал	-	10,660.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	8,528.17
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,132.04
210205	Эрүүл мэндийн даатгал	6,480,520.97	6,093,643.52
2104	Хангамж, бараа материалын зардал	14,437,200.00	12,397,438.00
210401	Бичиг хэрэг	927,200.00	737,038.00
210402	Тээвэр, шатахуун	12,105,400.00	10,270,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	963,400.00	835,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	441,200.00	555,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,227,700.00	10,846,985.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	231,600.00	540,000.00
210604	Урсгал засвар	996,100.00	10,306,985.00
2107	Томилолт, зочны зардал	1,085,000.00	3,820,000.00
210702	Дотоод албан томилолт	1,085,000.00	3,820,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,896,300.00	7,906,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,114,200.00	1,247,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	6,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,100.00	187,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,180,731.53	38,339,923.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,714,764.00	24,094,288.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,465,967.53	14,245,635.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	705,112.08	3,726,024.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	705,000.00	3,726,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	705,000.00	3,726,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	112.08	24.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	112.08	24.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,081,931.53)	(7,775,500.21)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,081,931.53)	(7,775,500.21)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,997,652.44		45,910,291.24	84,907,943.68
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,997,652.44		45,910,291.24	84,907,943.68
Тайлант үеийн үр дүн			(7,024,279.53)	(7,024,279.53)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,997,652.44		38,886,011.71	77,883,664.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,997,652.44		38,886,011.71	77,883,664.15
Тайлант үеийн үр дүн			(7,775,500.21)	(7,775,500.21)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,997,652.44		31,110,511.50	70,108,163.94

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>376,605,687.92</u>	<u>376,971,195.31</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,000.00	1,522,919.57
120	Нийтлэг татварын бус орлого	20,000.00	1,522,919.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000.00	-
120009	Бусад орлого	-	1,522,919.57
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	376,585,687.92	375,448,275.74
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	376,585,687.92	375,448,275.74
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	376,585,687.92	375,448,275.74
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>376,635,687.92</u>	<u>375,804,275.74</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	376,635,687.92	375,804,275.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,930,687.92	372,078,275.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,284,466.95	305,882,400.00
210101	Үндсэн цалин	211,178,066.95	192,947,300.00
210102	Нэмэгдэл	102,106,400.00	109,281,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,000,000.00	2,646,000.00
210104	Урамшуулал	1,000,000.00	1,008,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,480,520.97	6,205,575.74
210205	Эрүүл мэндийн даатгал	6,480,520.97	6,205,575.74
2104	Хангамж, бараа материалын зардал	14,697,000.00	11,817,500.00
210401	Бичиг хэрэг	1,023,300.00	886,900.00
210402	Тээвэр, шатахуун	12,269,100.00	9,539,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	963,400.00	835,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	441,200.00	555,700.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,531,200.00	14,897,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	4,050,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600,000.00	540,000.00
210604	Урсгал засвар	931,200.00	10,307,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,085,000.00	3,820,000.00
210702	Дотоод албан томилолт	1,085,000.00	3,820,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,946,300.00	7,926,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,164,200.00	1,267,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,100.00	187,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,906,200.00	21,529,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	131,200.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,775,000.00	21,529,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	705,000.00	3,726,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	705,000.00	3,726,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	705,000.00	3,726,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(30,000.00)	1,166,919.57
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(30,000.00)	1,166,919.57
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	50,000.00	20,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,000.00	1,186,919.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан төгрөгөөр

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	375,448,300.00	375,448,275.74	24.26	100.0
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	375,448,300.00	375,448,275.74	24.26	100.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	372,058,300.00	372,058,275.74	24.26	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,970,300.00	59,970,300.00		100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	305,882,400.00	305,882,400.00		100.0
210101	Үндсэн цалин	192,947,300.00	192,947,300.00		100.0
210102	Нэмэгдэл цалин	109,281,100.00	109,281,100.00		100.0
210103	Унаа хоолны нэмэгдэл	2,646,000.00	2,646,000.00		100.0
210104	Урамшуулал	1,008,000.00	1,008,000.00		100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,205,600.00	6,205,575.74	24.26	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,205,600.00	6,205,575.74	24.26	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	11,817,500.00	11,817,500.00		100.0
210401	Бичиг хэрэг	886,900.00	886,900.00		100.0
210402	Тээвэр, шатахуун	9,539,900.00	9,539,900.00		100.0
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	835,000.00	835,000.00		100.0
210406	БҮТЭЗүйлс	555,700.00	555,700.00		100.0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,897,000.00	14,897,000.00		100.0
210601	Багаж,техник хэрэгсэл	4,050,000.00	4,050,000.00		100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	540,000.00	540,000.00		100.0
210604	Урсгал засвар	10,307,000.00	10,307,000.00		100.0
2107	Томилолт, зочны зардал	3,820,000.00	3,820,000.00		100.0
210702	Дотоод албан томилолт	3,820,000.00	3,820,000.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,906,800.00	7,906,800.00		100.0
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,247,300.00	1,247,300.00		100.0
210802	Аудит баталгаажуулалт,зэрэглэл тогтоох	6,000,000.00	6,000,000.00		100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	187,500.00	187,500.00		100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00		100.0
210806	Мэдээлэл,технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00		100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,529,000.00	21,529,000.00		100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,529,000.00	21,529,000.00		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,390,000.00	3,390,000.00		100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,390,000.00	3,390,000.00		100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,390,000.00	3,390,000.00		100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	375,448,300.00	375,448,275.74	24.26	100.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	375,448,300.00	375,448,275.74	24.26	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	375,448,300.00	375,448,275.74	24.26	100.0
9001	Удирдах ажилтан		1	1	100.0
9002	Гүйцэтгэх ажилтан		20	20	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд цахим баримтын бүрдүүлэлт, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл, аудитор Я.Оюун, шинжээч Ц.Цацрал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитор Б.Дашням хэрэгжүүллээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн эрхэм зорилго нь нийгэмшүүлэх ажлын хүрээнд хүмүүжигчдэд мэргэжлийн боловсрол олгож, ажлын байраар хангах, гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх боломжийг бүрдүүлэх, эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц мэргэжлийн ур чадвартай ажилтан бэлтгэхэд оршино.

Тус төв нь Боловсрол, шинжлэх ухааны яамны 2012 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн №2012/009 дугаар сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу барилгын цахилгаанчин, засал чимэглэлчин, сантехникч, өрөг угсрагч, мужаан, бетон арматурчин, гагнуурчин, тогооч чиглэлээр сургалт зохион байгуулдаг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Б/487 дугаар тушаалаар төвийн бүтэц орон тоонд өөрчлөлт орж, удирдлага санхүү аж ахуй, сургалтын алба гэсэн бүтцээр 22 алба хаагчийн орон тоотой ажиллаж байгаад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар уран дарханы багш орон тоо хасагдаж, нийт 21 алба хаагчийн орон тоотойгоор ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн 384,239.4 мянган төгрөгийн нийт зардлаас 2.0 хувиар буюу 7,684.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,795.5 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал 1,239.2 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө 7,512.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20.0	1,186.9	1,166.9
Авлага	-	50.5	50.5
Бараа материал	43,128.8	41,889.6	(1,239.2)
Үндсэн хөрөнгө	34,754.8	26,981.1	(7,773.7)
Нийт хөрөнгө	77,903.6	70,108.1	(7,795.5)
Дансны өглөг	20.0	-	(20.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	38,997.7	38,997.6	(0.1)
Өмнөх үеийн үр дүн	38,886.0	38,886.0	-
Тайлант үеийн үр дүн	-	(7,775.5)	(7,775.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	77,903.7	70,108.1	(7,795.6)

Мөнгөн хөрөнгийн дансны 1,186.9 мянган төгрөгийн үлдэгдэл ахмадын сангийн дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө байна.

Авлага дансны үлдэгдэлд Нийгмийн даатгал хэлтэс болон татварын байгууллагаас авах 50.5 мянган төгрөгийн авлага байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 26,981.1 мянган төгрөг болж 7,773.7 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлаас шалтгаалжээ. Тайлант онд үндсэн хөрөнгө худалдаж авсан 3,313.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж болон данс хооронд шилжүүлсэн 3,158.8 мянган төгрөгийн хөрөнгийн дүнгээр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 70,108.1 мянган төгрөг болж 7,775.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,561.1 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 831.4 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан нь санхүүжилт буурч, цалин хөлс болон нэмэгдэл 632.3 мянган төгрөг, хангамжийн зардал 7,851.0 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 461,574.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 461,574.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 375,448.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 375,448.3 мянган төгрөгийн төсвийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 375,448.3 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, урсгал үйл ажиллагаанд 375,448.3 мянган төгрөгийг зарцуулсан.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70705	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	375,448.3	375,448.3	-	100.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	372,058.3	372,058.3	-	100.0
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	3,390.0	3,390.0	-	100.0

/мянган төгрөгөөр/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд зөрчилтэй асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлого, стандартад өөрчлөлт ороогүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 9 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд 150 мэдээллээс 29,506.9 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх;” 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илрүүлсэн нийт 7,150.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 7,150.7 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа 5,627.8 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын цахим баримтыг бүрдүүлээгүй, татварын цахим хуудсанд шивэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.1 "албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа цахим баримтыг тухай бүр бүрдүүлэх, татварын и-баримт цахим хуудсанд бэлтгэн нийлүүлэгч и-баримтыг шивсэн эсэхэд хяналт хэрэгжүүлэх.

2. Ахмадын сантай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Цалингийн зардлаас хэмнэгдсэн 1,522.9 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Ахмадын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхдээ цалингийн зардлаас бусад хэмнэгдсэн зардлаас бүрдүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр, аудитын код	Алдаа, зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
						Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар															
1	ШШЕГ-ын МСҮТ АХГ-2022/251/НА-СТА-ТШЗ	Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа нэмэгдсэн өртгийн албан татварын цахим баримтыг бүрдүүлээгүй, татварын цахим хуудсанд шивэгдээгүй байна.	Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа цахим баримтыг тухай бүр бүрдүүлэх, татварын и-баримт цахим хуудсанд бэлтгэн нийлүүлэгч и-баримтыг шивсэн эсэхэд хяналт хэрэгжүүлэх	1	5,627.8									1	5,627.8
2		Цалингийн зардлаас хэмнэгдсэн 1,522.9 мянган төгрөгийг ахмадын сан байгуулж төвлөрүүлсэн байна	Ахмадын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхдээ цалингийн зардлаас бусад хэмнэгдсэн зардлаас бүрдүүлж байх.	1	1,522.9										1
Дүн				2	7,150.7									2	7,150.7
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал															
1	ШШЕГ-ын МСҮТ АХГ-2022/251/НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд 150 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд бүрэн байршуулж байх	1	29,506.9									1	29,506.9
Дүн				1	29,506.9	-	-	-	-	-	-	-	-	1	29,506.9
Нийт дүн				3	36,657.6									3	36,657.6

